

**“БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГ
2019 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БИЕЛЭЛТ**

2019 оны 04 дүгээр сарын 30

Багануур дүүрэг

№	Үндэслэл	Хийсэн ажлын биелэлт	Гүйцэтгэлийн хувь
1	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 1.2	Парк-Суралцагч байгууллага болох ажлын хүрээнд “Багануур 40 жил – 40 инноваци” аянд нэгдэж 40 айл өрхөд ахуйн хаягдлаар бордоо хийх сургалт зохион байгуулах талаар хамт олны хурал дээр хэлэлцсэн.	100%
2	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 2.1.	Хүний нөөцийн бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд дүүргийн хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэстэй хамтран ажиллаж байна.	100%
3	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1.	Олон улсын төсөл, хөтөлбөрт хамрагдах, Засгийн газрын дэмжлэг авах боломж гарцуудыг судалж удирдлагад танилцуулсан.	100%
4	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1.	Мон–Энержи Консалт” ХХК-ийн гүйцэтгэж байгаа паркийн бүсүүдийн дэд бүтцийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлт, гадна инженерийн шугам сүлжээний төслийн гүйцэтгэлд хяналт тавьж 4 сарын 3,12,19-нд ХЕТ, дэд бүтцийн инженер Улаанбаатар хотод ажиллан шаардлагатай мэдээллүүдээр хангасан. Мөн цахилгааны техникийн нөхцөлийн асуудлаар ЭХЯ, БХТ-тэй хамтарсан уулзалт хийж шийдэлд хүрсэн.	100%
5	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 12.1	Дүүргийн ЖДҮДТ-тэй жижиг дунд үйлдвэрлэлд инновацийг нэвтрүүлэх чиглэлээр хамтарсан уулзалт зохион байгуулахаар саналыг тавьсан.	100%
6	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 9.1	МУИС болон ШУТИС-ийн удирдлагуудад цаг үеийн шинжтэй ажил гарсан тул гэрээ байгуулах ажил хойшлогдсон.	0%
7		ЕБСБХ-ийн удирдлагатай уулзаж гэрээ байгуулахгүйгээр хамтарсан ажил зохион байгуулах төлөвлөгөө гаргаж гүйцэтгэхээр тохиролцсон.	80%
8		Биотехнологийг хөгжүүлэх суурь судалгааны чиглэлээр ХААИС болон ШАУИС-тай хамтран ажиллах санал дэвшүүлж уулзалт зохион байгуулж хамтран ажиллах чиглэлүүдээ нарийвчлан тогтсон.	100%
9		УХЭШХ-тэй 2019.04.11-нд хамтран ажиллах гэрээ байгуулсан. Тус гэрээний хүрээнд хамтын ажиллагааг эхлүүлсэн.	100%
10	“БҮТП” ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 15.2	“БИДНИЙ ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдэвт сар бүрийн 9-ний өдөр дүүргээс зохиох арга хэмжээний хүрээнд 5 айлын ахуйн хог хаягдлаар бордоо хийсэн туршилтын үр дүнг шалгаж зөвлөгөө өгсөн.	100%

11	"БҮТП" ОНӨТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 20.1	Дүүргийн Засаг даргын нэрэмжит "Хөдөлгөөн эрүүл мэнд" сэдэвт биеийн тамир спортын VII их наадамд МХС, МЦХ, ШХГ, үүрэн телефоны операторууд гэсэн хамтарсан баг амжилттай оролцож, сагсан бөмбөгийн эмэгтэй төрөл дэд байр эзэлсэн.	100%
12	Нийслэлийн архивын газрын 2019.03.05-ны өдрийн 02/87 тоот албан бичиг	2019.04.05-нд Архивын газраас байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд иж бүрэн хяналт шалгалт хийх төлөвлөгөөтэй байсан боловч одоогоор ирээгүй байна.	100%
Нэмэлт ажлууд			
13	2019.04.03 нд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын чадавх бэхжүүлэх хөтөлбөрийн хүрээнд захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдэд зориулсан Илтгэх ур чадварын үндэс болон UB ERP дотоод удирдлагын системийн хэрэглээ гэсэн 2 сургалтад М.Мөнхдулам, Б.Мичид-Эрдэнэ нар хамрагдсан.		100%
14	2019.04.04-нд Хүн амын бие бялдар хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг авах аргачлал ба мэдлэг, хандлагыг нэмэгдүүлэх сэдэвт сургалтад ХЕТ, дэд бүтцийн инженер Б.Мөнгөнхуяг оролцсон.		100%
15	2019.04.05 нд дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсээс зохион байгуулсан "Хайраар дутвал - Хайраар дутаавал" сэдэвт Гэр бүл судлаач, шинжлэх ухааны доктор, профессор Т.Намжил багш лекцэд байгууллагын Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дарга Б.Мөнгөнхуяг хамрагдаж сургалтын талаар мэдээлэл өгсөн.		100%
16	2019.04.13-нд LEAD MONGOLIA манлайллын хөтөлбөрийн танилцуулга уулзалтад М.Мөнхдулам, Б.Мичид-Эрдэнэ нар оролцсон.		100%
17	2019.04.23-нд Монголын мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүдийн холбооны гүйцэтгэх захирал С.Даваанямын "Аюулгүй байдал байгууллагын соёл" сэдэвт сургалтад ахлах мэргэжилтэн Б.Мичид-Эрдэнэ хамрагдаж сургалтын талаарх мэдээ мэдээллийг хамт олонд танилцуулсан.		100%
18	2019.04.04-05-ны өдрүүдэд Инновацийн сангаас зохион байгуулсан төслийн сургалтад Ахлах мэргэжилтэн Д.Алтангэрэл хамрагдаж, эхний шатанд тэнцсэн 2 төслийг шинэчлэн боловсруулж 2019.04.23-нд илгээсэн.		100%
19	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн А/285 дугаар захирамж, дүүргийн Засаг даргын А/111 дүгээр захирамжийг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019.04.20-нд хуваарилагдсан газарт их цэвэрлэгээ хийж тайлан дүүргийн ЗАА-нд хугацаанд нь илгээсэн.		100%

ХЯНАСАН:

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:



Ч.ЭЛБЭГСАЙХАН

“Багануур Үйлдвэрлэл, Технологийн Парк” ОНӨТҮГ-ын дарга

Б.Мичид-Эрдэнэ
Ахлах мэргэжилтэн